

**СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН СУМЫН НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “НУТГИЙН АНАР” ХХК- ИЙН
“БҮРЭНЦОГТЫН ГЯНТБОЛДЫН ОРД АШИГЛАХ”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-013470,/
/ АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 519213/

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1. Төслийн нэр

“Бүрэнцогтын гянтболдын орд ашиглах” төсөл

1.2. Төслийн зорилго

Бүрэнцогтын гянтболдын ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлээр тус ордыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар далд аргаар ашиглан олборлолт явуулахад тус төслийн зорилго оршино.


1.3. Төсөл хэрэгжүүлэгч

“Нутгийн Анар” ХХК	
Улсын бүртгэлийн дугаар	9011137003
Хаяг	Улаанбаатар хот, ХУД дүүрэг, 17-р хороо, “Z бизнес центр” барилга 1004 тоот
Холбоо барих утас	88885663

“Нутгийн Анар” ХХК нь 2015, 2022 онуудад “Мон Газар Экологи” ХХК-иар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн бөгөөд 2019 болон 2024, 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлыг “Мон Газар Экологи” ХХК гүйцэтгэсэн байна.

1.4. Төслийн байршил

Бүрэнцогтын гянтболдын орд газар нь засаг захиргааны харьяаллаар Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг дэвсгэрт байрлана. Мөнххаан сумын төвөөс баруун урагш 45 км, Баруун-Урт хотоос баруун урагш 130 км, Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотоос зүүн урагш 110 км, Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 440 км-т тус тус оршино.



Зураг 1. MV-013470 дугаар бүхий тусгай зөвшөөрлийн талбайн байршлын тойм зураг

Хүснэгт 1. MV-013470 дугаар бүхий тусгай зөвшөөрлийн талбайн координат

№	Уртраг			Өргөрөг		
1	111	42	57.04	46	44	1.7
2	111	42	32.05	46	44	1.7
3	111	42	32.05	46	44	21.69
4	111	43	22.04	46	44	21.69
5	111	43	22.04	46	44	46.69
6	111	43	47.04	46	44	46.69
7	111	43	47.04	46	44	18.7
8	111	42	57.04	46	44	18.7

1.5. Төслийн хүчин чадал, ажиллах горим

Уурхайн жилийн хүчин чадлыг малталт нэвтрэлтийн хурд, олборлолтын мөргөцгийн ахилтын хурд, баяжуулах фабрикийн хүчин чадал зэргээс хамааруулан тооцсон байна.

➤ Үйлдвэрлэлийн нийт нөөц	12,667.1 тн
➤ Олборлолтын жилийн хүчин чадал	11.0 мян.тн
➤ Уурхайн ажиллах нийт хугацаа	2.8 жил
➤ Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	200 тн/хоног
➤ Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	42.0 мян.тн

Олборлолтын ажиллах горим: Уурхай нь жилийн турш тасралтгүй журмаар ажиллавал 1 жилд 353 хоног ажиллана. 1 сард 25-31 хоног, 1 хоногт 7-11 цаг ажиллана.

Баяжуулалтын ажиллах горим: 1 жилд 210 хоног, хоногт 2 ээлж тус бүр 10 цагаар ажиллана.

1.6. Төслийн технологи

Тус төсөл нь олборлох болон баяжуулах үйл ажиллагаа явуулна. Олборлолтын үйл ажиллагааг далд аргаар, баяжуулалтыг нойтон соронзон баяжуулалтын аргаар тус тус гүйцэтгэнэ.

1.6.1. Олборлолтын технологи

Бүрэнцөгт гянтболдын ордын хүдрийн биетийн уналын өнцөг харьцангуй их буюу ордын хэмжээнд 80-85⁰, хүдрийн биетийн зузаан харьцангуй бага буюу 0.9 м байгаа нь далд аргаар ашигт малтмалын тогтоогдсон нөөцийг бүрэн дүүрэн олборлох боломжтойг харуулж байна. Ордыг ашиглах далд уурхайн хүрээ хязгаарыг нарийвчилсан хайгуулын ажлаар тогтоогдсон ашигт малтмалын хүдрийн биетийн бодит В зэргийн нөөцийн блокийн хилээр хязгаарлагдана. Олборлолтын үйл ажиллагаа нь уурхайг нээх, уурхайн талбайг ашиглалтад бэлтгэх, ашиглалт явуулах гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Ашиглалтын технологи. Хүдрийн биет нь бага зузаантай, босоо уналтай учир олборлосон орон зайг ил үлдээх ангиллын шпурын цэнэгээр нураах хоршоолсон ашиглалтын систем сонгож авсан байна. Энэ системд камерыг доороос нь дээш олборлох ба нураасан хүдрийг хоршоолон ажилчид ажиллах 2м-ийн өндөртэй орон зайг үлдээн тэндээш шпур өрөмдөн олборлолтыг явуулах учир өрөмдлөгийн малталт шаардагдахгүй сайн талтай. Хүдрийн биетийн 4м гүн хүртэл шпурын цэнэгээр нураан хоршоолж түүнээс дээш өрмийн цооноогоор нурааж ашиглана. Мөргөцгөөс хүдрийг тэслэн нураасны дараа түүний 25-35%-ийг доош хүдэр буулгуураар буулгана. Камер дахь нөөцийг бүрэн олборлосны дараа хүдрийг нийтэд нь буулгана.

1.6.2. Баяжуулалтын технологи

Бүрэнцөгтын гянтболдын ордын баяжуулалтанд нойтон соронзон сепраторын аргыг ашиглана. Баяжуулалтын процесс нь дараах үе шатыг дамжин явагдана.

- Хүдэр бэлтгэх ажиллагаа
- Үндсэн баяжуулалт
- Соронзон баяжуулалт

1.7. Төслийн тоног төхөөрөмж

Хүснэгт 2. Уулын үндсэн тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Зориулалт	Хэмжих нэгж	Хүчин чадал
1	Гар перфератор	УТ-28	өрөмдөх	Дж	73
2	Малтагч скреппер	2JPB-7.5	малтах	м ³ /цаг	4
3	Ачигч скреперийн	P15B(B)	ачигч	м ³ /цаг	15-25
4	Вагонетка	KFU0.75-6	тээвэрлэх	м ³	0.75
5	Зүтгүүр	CJY-15	тээвэрлэх	кВт	6.5

6	Төмөр зам	A-55	тээвэрлэх		
7	Бадья	TG-1.0	өргөх	м ³	1
8	Клет	GLG(S)-1x1x1	зорчих	хүн	9
9	Өргөгч цамхаг	JZ-10/800	өргөх	кВт	22
10	Даралтат хийн төхөөрөмжид	KHE-15/8		м ³ /мин	2.5

Бүрэнцогтын гянтболдын ордын баяжуулалтанд нойтон соронзон сепраторын аргыг ашиглана.

Хүснэгт 3. Баяжуулалтын тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Зориулалт	Хэмжих нэгж	Хүчин чадал
Бэлтгэл ажиллагаа					
1	Хацар бутлуур	PE250x1000	бутлах	тн/цаг	13
2	Конусан бутлуур	SC cone	бутлах	тн/цаг	16
3	Доргиурт шигшүүр-1	ZD – 918 Z	шигших	тн/цаг	40-50
4	Тэжээгүүр	GZ3			
5	Туузан конвейер	DT75-650	дамжуулах	тн/цаг	127
Үндсэн баяжуулалт					
6	Баяжуулах ширээ	L-S(6-S)	баяжуулах	тн/цаг	0.8-1.5
7	Тунаах машин	LTA-1010/2	тунаах	тн/цаг	5-15
8	Бөмбөлөгт тээрэм	Ф900×1800	нунтаглах	тн/цаг	0.65-2
Соронзон баяжуулалт					
10	Нойтон соронзон сеператор	СТ406	Соронзон баяжуулах	тн/цаг	2-4
11	Даралтат филтър/баяжмал/	YLY-250	шүүх	кг/цаг	100

1.8. Туслах материал, эцсийн бүтээгдэхүүн, хог хаягдал

1.8.1. Усны хэрэглээ

Уурхай нь ашиглалтынхаа үед дараах зориулалтаар ус ашиглана.

- Технологийн хэрэглээ
- Техникийн хэрэглээ
- Ахуйн хэрэглээ

Технологийн хэрэглээ. Баяжуулах үйлдвэрийн усан хангамжийг ус татах байгууламж /усан сангаас/-с хангах бөгөөд нийт хэрэглэгдэх технологийн усны хэрэглээний 80%-г эргүүлэн ашиглана. 1 тн хүдрийг баяжуулахад 2.87 м³ ус шаардлагатай байна.

Техникийн хэрэглээний ус. Бүрэнцогтийн уурхайн хувьд далд уурхайн учир техникийн хэрэглээний ус харьцангуй бага байна. Техникийн хэрэглээний усны хэмжээ жилд 70 м³ байна.

Унд-ахуйн усны хэрэглээ. Ундны болон ахуйн усны хэрэглээнд хоол ундны болон ажилчдын болон уурхайн ахуйн хэрэглээний усны хэмжээ хамаарна. БОАЖЯ-ны сайдын 2015 оны А/301-р тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ыг баримтлан нэг хүний хоногийн усны хэрэглээ 125 л-ээр тооцсон.

Хүснэгт 4. Нийт усны хэрэглээ

Ашиглалтын жил	1 жил	2 жил	3 жил
Технологийн ус/30% цэвэр/, мян.м ³	36.162	21.0428	5.39847
Техникийн хэрэглээний ус, м ³	100	100	100
Ахуйн хэрэглээний ус, мян.м ³	5.565	5.1975	1.314
Нийт усны хэрэглээ, мян.м ³	41.827	26.3403	6.81247

1.8.2. Шатах гөслөх материалын хэрэглээ

Нийт 2 тоног төхөөрөмж олборлолтын үйл ажиллагаанд ашиглагдана. Эдгээрийн шатах ууны хэрэглээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5. Шатахууны хэрэглээ

№	Тоног төхөөрмжийн нэр	Тоо	1 хоногт ажиллах цаг	Шатахуун зарцуулалт	Шатахууны хэрэглээ, мян.л		
					1 хоног	1 сар	1 жил
1	Автосамосвал HOWO	1	20.4	30	4.8	144	1728

2	Дугуйт ачигч ZL50E	1	20.4	28	0.57	17.14	177.07
---	--------------------	---	------	----	------	-------	--------

1.8.3. Эцсийн бүтээгдэхүүн

Тус гянтболдын орд ашиглах төслийн олборлолтын эцсийн бүтээгдэхүүн нь 60% агуулгатай 72472 тн баяжмалыг 3 жилийн хугацаанд олборлоно.

1.9. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил

Эдийн засаг, дэд бүтцийн хувьд харьцангуй сайн хөгжсөн. Улаанбаатар хотоос Өндөрхаан хүртэл хатуу хучилттай замаар 330 км, цааш 110 км ямар ч улиралд чөлөөтэй зорчих боломжтой шороон замаар холбогддог. Орд орчимд Мөнххаан сумын 5-р багийн төв байрлана. Энд багийн захиргаа, худалдаа үйлчилгээний дэлгүүр, зочид буудал зэрэг газрууд байрлана. Хамгийн ойр байрлах Тал булаг нүүрсний уурхайгаас 120км –с байдаг нь түлшний хэрэгцээг эндээс хангаж болох талтай. Үйлдвэрлэлийн болон ахуйн усан хангамжийг худаг, өрмийн цооногоор гаргасан гүний худгаар хангана.

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн гол сөрөг нөлөөлөл

- Төслийн олборлолтын үе шатанд буюу хөрс хуулалт, тээвэрлэлт, хадгалалт болон баяжуулах үйл ажиллагааны үед салхины горим, нийлбэр цацрагийн хэмжээ зэрэг хүчин зүйлсийн улмаас үүсэх тоосонцор, шимт хөрснийг хадгалах газрын сонголт, дотоод овоолгоос үүсэх тоосонцрын тархалт зэрэгт нөлөөлөх;
- Уурхайн карьер, шимт хөрс, хөрсний гадаад, дотоод овоолго болон тээвэрлэлтийн үеийн тоосонцрын тархалт, автомашины утаанаас ялгарах бохирдуулагч бодисууд зэргийн агаар мандал дахь тархалт
- Орчны тоосжилтод байнгын хяналт тавьж, тоосжилтыг бууруулахын тулд салхи ихтэй, хуурайшилттай үед зам талбайг чийглэж услах;
- Шимт хөрсний овоолго ургамалжуулан хамгаалах. Энэ нь шимт хөрсний чанарыг алдагдуулахгүй байх мөн тоосжилт үүсэхээс сэргийлэх талтай;
- Газрын гадарга элэгдэл эвдрэлд өртсөнөөр хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөг, хөрс шүтэн амьдрагч амьтны амьдрах орчин, аюулгүй байдал, агаарын тоосжилт гээд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд шууд болон дам байдлаар нөлөөлөх
- Төслийн үйл ажиллагаанаас шууд нөлөөлөлд өртөх газрын гадаргын шимт хөрсийг хуулж, MNS 5916:2008 стандартын дагуу хадгалах;
- Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих
- Хүчтэй салхи шуурга, түймэр, газар хөдлөл, аянга зэрэг байгалийн гамшгаас үүдэн аюул, осол гарах;
- Санамсар, болгоомжгүйн улмаас гал алдах, түймэр гарах. Энэ тохиолдолд экосистем бүхэлдээ хэвийн үйл ажиллагаагаа алдах аюултай.
- Техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-д хөдөлмөр аюулгүй байдлын талаар хангалттай тусгаж өгөөгүйгээс уурхайд осол аваар гарах, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдэх юм.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д зааснаар “Нутгийн анар” ХХК нь “Бүрэнцогтын гянтболдын ордыг далд аргаар ашиглах” төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургалтад хамрагдах боломжтой болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум орон нутгийн удирдлага, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

“Нутгийн Анар” ХХК-ийн “Бүрэнцогтын гянтболдын орд ашиглах” төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг 2015, 2022 онд мөн 2019 онд тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлыг “Мон Газар Экологи” ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн байсан.

”Нутгийн Анар” ХХК нь 2020, 2021, 2022, 2023, 2024 онуудад Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 5 дугаар багийн нутагт орших MV13470 тоот тусгай зөвшөөрөл бүхий Бүрэнцогтын гянтболдын ордыг эзэмшдэг “Нутгийн-Анар” ХХК нь үйл ажиллагаа явуулаагүй ба сумын засаг даргын тамга, гарын үсэг бүхий (хавсралт) -ыг хавсаргав.

2022 онд хийгдсэн БОННУ-ний тайланд тусгасан төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОМТ)-ийн дагуу тухайн жилийн БОМТ-г хууль, журмын дагуу боловсруулав.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Нутгийн анар” ХХК нь “Бүрэнцогтын гянтболдын ордыг далд аргаар ашиглах” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл “бага” эрчимтэй боловч үйл ажиллагаанаас гарах ахуйн шингэн хаягдал, хатуу хог хаягдлаас үзүүлэх нөлөөлөл, хөрс, ургамал, газрын доорх ус болон бусад хам бүрдэлд үзүүлэх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арилгах, бууруулах үүднээс төслийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах хууль, журам, стандарт
Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлуулах арга хэмжээ								
Тээврийн хэрэгсэлд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж байх мөн шаардлагатай бол түлшний бүрэн шаталтыг дэмжих төхөөрөмжүүдийг техникүүд дээр суурилуулах.	Агаарын чанар	ш/удаа	/4 ш техник ашиглана/	Үйл ажиллагааны зардалд тусгах	2.500.000	“Нутгийн анар” ХХК	-	MNS 4597 : 2014
Олон салаа зам гарахаас урьдчилан сэргийлж дотоод болон гадаад замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийж тогтмол арчилж байх .	Хөрс хамгаалал	ш	4	100,000	400,000	“Нутгийн анар” ХХК	-	
Уурхайн гадаргуун замууд дээр хоёр талаар нь шороон далан хөмсөг хийх	Хөрс хамгаалал	метр	1500	Уурхайн техникийг ашиглан хийлгэх		“Нутгийн анар” ХХК		
Уурхайн ажилчид, суурин дахь захиргаа-үйлчилгээний ажиллагсдын зорчих явган хүний зам, талбайг зориулалтын хайрган хучилттай болгох	Хөрс хамгаалал	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой				“Нутгийн анар” ХХК	-	MNS 5973 : 2009
Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх	Хөрс хамгаалал							“Нутгийн анар” ХХК
Уурхайн талбайн хог хаягдлыг цэвэрлэх, эдэлбэр газар түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайн цэвэрлэгээг хийх эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх, нөхөн сэргээх	Хөрс хамгаалал			1,500,000		“Нутгийн анар” ХХК	-	“Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай”

Уурхайн шавхан зайлуулах усны төлбөрийг тухайн жилийн ус ашиглах дүгнэлт, ус ашиглуулах гэрээнд заасан дүнгээр төлбөрийг барагдуулсан байх	Төслийн хэмжээнд	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			“Нутгийн Анар” ХХК	Төлбөр төлсөн баримт	“Усны тухай хууль”
Нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Зам талбайн тоосжилтыг бууруулах, дотоод тээврийн зам, хөрсний овоолгоос үүсэх тоосжилтыг бууруулах	Агаарын чанар	м ²	Жилд 3 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		“Нутгийн анар” ХХК	Мэргэжлийн байгууллага	MNS 6230 : 2010 MNS 5342:2007. MNS 5924 : 2015 “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн Усны тухай хууль “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”
Ариун цэврийн байгууламж, бохир усны цооног, хог хаягдлын цэг нийт 3 цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хөрс, газрын доорхи ус, ургамлан нөмрөг	3 цэгт	Жилд 2 удаа	150,000	900,000	“Нутгийн анар” ХХК	Мэргэжлийн байгууллага	
Нийт				5,300,000 төгрөг				

6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагаа дуусаагүй байгаа учир дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг 2026 онд авч хэрэгжүүлэхгүй болно.

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь аливаа хууль эрхзүйн хүрээнд хязгаарласан болон хориглосон талбайд хамаарахгүй. Мөн айл өрхийн бэлчээрийн болон эзэмшил газартай давхцалгүй учир нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговорын үйл ажиллагаа явуулах шаардлагагүй болно.

8. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баритлах эрх зүйн баримт
Элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээн, ногоон байгууламж бий болгох	Орчны тохижилтыг сайжруулан, талбайд мод тарих	Улиас	ширхэг	50	5,500	1,390,000	Төсөл хэрэгжих хугацаанд	Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт - MNS5914:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт. MNS5916:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага.
		Улиангар	ширхэг	50	11,000			
		Хайлаас	ширхэг	100	4,500			
		Гүйлс	ширхэг	100	11,500			
		Нийт	ширхэг	300	2,150,000			
Ногоон байгууламж байгуулах зардал		Агротехникийн ажиллагаа	-	-	-	1,500,000		
		Суулгацыг тээвэрлэх зардал	-	-	-	250,000		
		Ажилчдын хөлс	-	-	-	-		
Тоосжилтоос сэргийлэх зорилгоор мод, зүлгийг тогтмол услах	Ногоон байгууламжийн усалгаа тайралт, хэлбэржүүлэлт хийх	Төслийн талбай	-	Жилд 1 удаа	-	-		
			-					
			-					
Нийт зардал		3,140,000						

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн талбай орчимд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
Осол эрсдлээс хамгаалах арга хэмжээ								
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах хянах	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Тогтмол	-	-	“Нутгийн Анар” ХХК	Өдөр бүр, тогтмол ажил эхлэхээс өмнө	<ul style="list-style-type: none"> - Гамшгаас хамгаалах тухай хууль - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй: Дуу чимээ болон ерөнхий аюулгүй байдлын шаардлага - MNS 4244:1994 ХХСС. Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт		Сард 1 удаа	Зардал тусгагдаагүй	“Нутгийн Анар” ХХК	Сургалтыг жилд 1 удаа		
	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт		Сард 1 удаа					
	Байгаль орчныг хамгаалах талаарх сургалтуудыг зохион байгуулах		Жилд 4 удаа					
	Ажилчдыг зориулалтын хувцас, бээлий, малгайгаар хангах, хангахдаа MNS 6654:2017 стандартыг баримтлах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа	2 ээлж	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	“Нутгийн Анар” ХХК	Байнга		
Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах		Иж бүрэн	-	1,500,000	“Нутгийн Анар” ХХК	Жилд 1 удаа		
Болзошгүй осол, далд уурхайн осол эрсдлийн улмаас ажилчдад	Ажилчдад гүний нөхцөлд ажиллах, нурах эрсдэлээс хамгаалах, аюулгүйн ажиллагааны талаар сургалт зохион байгуулах	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Тогтмол	500,000	500,000	“Нутгийн Анар” ХХК	Өдөр бүр, тогтмол ажил эхлэхээс өмнө	- Далд уурхайн аюулгүй байдлын дүрэм

гэнэтийн аюул гэмтэл үүсэх								
Нийт зардал						2,000,000		

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын эх үүсвэр нь уурхайд ажиллаж буй 50 хүний унд ахуйн хэрэглээ болон техник үйл ажиллагаанд ашиглагдах шатах тослох материал юм. Унд ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг хатуу, шингэн, хийн гэж ангилав.

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө									
Ахуйн хатуу хог хаягдал	Хатуу хог хаягдлын түр цэг байгуулах	Үйлдвэрийн хашаанд	1 ш/удаа	-	2.500,000	“Нутгийн Анар” ХХК			“Хог хаягдлын тухай хууль” “Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003 БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам”
Ахуйн хатуу хог хаягдал	Шаардлагатай байршил бүрт хог хаягдлыг ангилан хаях зориулалттай хогийн сав байрлуулах	Төслийн талбайд	1 ш	-	500,000	“Нутгийн Анар” ХХК			
Ахуйн хатуу хог хаягдал	Хог хаягдлын талаар ажилчдад мэдээлэл түгээх, танилцуулга хийх	Ажилчид	Жилд 1 удаа	-	-	“Нутгийн Анар” ХХК			
Хог хаягдал хуримтлагдах	Төслийн талбай орчныг бохирдуулахаас сэргийлж, сумын холбогдох байгууллагатай хамтран ойр орчимд тогтмол цэвэрлэгээ хийж байх	Ойр орчмын 50 метр газарт	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		“Нутгийн Анар” ХХК			
Удаан задардаг хатуу хог хаягдал үүсэх	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Төслийн хүрээнд	Тухай бүрд нь	Зардал тусгах шаардлагагүй.		“Нутгийн Анар” ХХК	Гэрээ байгуулж ажиллах		
Ялаа шавж үржих, өвчин гарах	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хатуу хог хаягдлын цэгт	Улирал бүр 1 удаа	Холбогдох байгууллагатай хийсэн гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр		“Нутгийн Анар” ХХК			
Нийт зардал							3,000,000		

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Нутгийн Анар” ХХК-ийн “Бүрэнцогтын гянтболдын орд ашиглах” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Агаар орчин

ОХШХ-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.

Усны чанар

Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөрсөн бүрхэвч

Хөрсний бохирдлын түвшинг дотоодын магадлан итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсэж болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана” хэмээн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2.7-д заасан байна. Үүний дагуу бид байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт
1. АГААР ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
1	Хорт хийн агууламж: Азотын давхар исэл (NO ₂ , NO, NO _x) Хүхэрлэг хий (SO ₂) Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO ₂), CO, HCN, O ₂	мкг/м ³	Уурхайн суурин 1 цэг, тээврийн зам дээр 1цэг, овоолго орчимд 1 цэг Уурхайн олборлолт явуулах 2 цэг, ШТС, автозогсоол орчимд 1 цэг Тэсрэх бодисын агуулгах 1 цэг	Жилд 2 удаа	150,000	2,400,000	“Нутгийн анар” ХХК	Мэргэжлийн байгууллага, судлаач	УСТ 3384-92 УСТ 3600-83 MNS 4048-88 MNS 4585-2007 MNS ISO 4227 : 2002 MNS 3113 : 1981 MNS 5028 : 2001
2	Агаарын тоос тоосонцор (PM _{2.5} , PM ₁₀)	мкм	Уурхайн дотоод зам 1 цэг Нийт 8 цэг						
3	Дуу чимээ	дБА	- Тайван байх үед - Тоног төхөөрөмж ажиллаж байх үед -Тээврийн зам дагуу - Ажилчдын байрны орчимд Нийт 4 цэгт	Жилд 2 удаа	100,000	800,000	“Нутгийн анар” ХХК		
2. УСАН ОРЧНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
4	Усны хими, физикийн үзүүлэлт Микробиологийн үзүүлэлт	мг/дм ³ 1 мл-т илрүүлэх 100 мл-т	Унд-ахуйн зөөврийн ус 1 дээж Гүний худгаас 1 дээж Хяналтын цооног 1 дээж Нийт 3 цэгт	Жилд 2 удаа	100,000	600,000	“Нутгийн анар” ХХК	Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн усны лаборатори, Ус цаг уур орчны шинжилгээний газар	MNS 900:2005
3. ХӨРС, УРГАМЛЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
5	Ялзмаг агууламж Урвалын орчин Хөрсний физик, химийн шинж чанар	мг/кг %	Уурхайн суурин 1 цэг, тээврийн зам дээр 1цэг, овоолго орчимд 1 цэг	Жилд 2 удаа	120,000	1,920,000	“Нутгийн анар” ХХК	Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн	УСТ 3298-90 УСТ 3297-91 MNS 5850-2008 MNS ISO 10390 : 2001

Хөрсний хүнд металлын агууламж Нийт азот, фосфор	Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн		Уурхайн олборлолт явуулах 2 цэг, ШТС, автозогсоол орчимд 1 цэг Тэсрэх бодисын агуулгах 1 цэг Уурхайн дотоод зам 1 цэг <i>Нийт 8 цэг</i>					Хөрс судлалын лаборатори, Магадлан итгэмжлэгдсэн хөрсний лабораториуд	MNS (ISO) 11260 : 2000 MNS ISO 11269-1 : 2002 MNS 5546 : 2005 MNS 3298 : 1991 MNS 3243 : 1989 MNS 5918 : 2008 MNS 2490 : 1977
Тухайг жилийн ОХШХ-ийн нийт						5,720,000			

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах хууль, журам, стандарт
1	Байгаль орчныг хамгаалах үүнтэй холбоотой асуудлыг БО мэргэжилтэнд хариуцуулж, өөрөө хяналт тавьж ажиллах	Төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх талбайн хүрээнд	-	-	-	Уурхайн дарга Уулын инженер	Байгаль орчны зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллага	- Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль
2	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг сунгуулж ажиллах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	-	-	-	Уурхайн дарга	Аймгийн онцгой байдлын газар	- Монгол улсын Галын аюулгүй байдлын тухай хууль
3	Ажилчдын дунд байгаль хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах - Байгаль орчныг хамгаалах - Гал түймрээс урьдчилан сэргийлэх /шаардлагатай үед гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж чаддаг байх/ - Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын сургалт	Бүх ажилчид	Жилд 1 удаа	500,000		“Нутгийн Анар” ХХК	Байгаль орчны мэргэжилтний оролцоотойгоор	- Сургалтанд хамрагдсан бүртгэл тэмдэглэл
4	Байгаль орчны аудит хийлгэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Жилд 1 удаа		-	Уурхайн дарга	Байгаль орчны аудитын мэргэжлийн байгууллага	- Монгол улсын байгаль хамгаалах тухай хууль - Монгол улсын Иргэний тухай хууль - Байгаль орчны аудит хийх, эрх олгох журам
5	Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын иргэдэд БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Жилд 1 удаа	-	-	Уурхайн дарга		- Монгол улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ тухай хууль - Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам

6	Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөр	-	-	Дотоод зардлаар	Захирал Үйлдвэрийн дарга		- “Газрын төлбөрийн тухай хууль”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах	-	-	-	Захирал Үйлдвэрийн дарга		- “Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
8	Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах	-	-	-	Захирал Үйлдвэрийн дарга		- MNS 6694:2017
9	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, Хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх		Тогтмол	80,000	Захирал Үйлдвэрийн дарга		-
10	Үйлдвэрийн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйлдвэрийн үйл ажиллагааны зардалд тусгах	Тогтмол	-	Захирал Үйлдвэрийн дарга		- MNS ISO 13688:2000
11	Уурхайн дотоод хяналтын ажлын хэсэг байгуулж өдөр тутам уурхайн үйл ажиллагааг шалгаж хяналт тавих	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Тогтмол	1,000,000	Захирал Үйлдвэрийн дарга		- Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль
12	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Тогтмол	7,000,000	Захирал Үйлдвэрийн дарга	Байгаль орчны зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллага	- Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам
Нийт							8,580,000

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ						
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Хэрэгжүүлэгч
Орон нутгийн байгаль орчны газар	Шинжээчдийн дүгнэлтээр баталгаажна.	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сарын 1	Шинжээчдийн дүгнэлт	Орон нутгийн байгаль орчны газар	“Нутгийн Анар” ХХК
Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 1-ний дотор	БОХ арга хэмжээний тайлан ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах	Дүүрэг, хороо	“Нутгийн Анар” ХХК
Төрийн бус байгууллага, олон нийт			Жил бүр 1 удаа		Тухайн үед сонгох	“Нутгийн Анар” ХХК
Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр		12-р сарын 10-ний дотор	Хянуулах батлуулах	Улаанбаатар хот	“Нутгийн Анар” ХХК
Нийт					-	

15.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал /2026 оны/

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний нэг жилийн дундаж зардлыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Зардлын хэлбэр	2026 он /мян.төг/
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	5,300,000
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	2,000,000
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт	3,140,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	3,000,000
Орчны хяналт шинжилгээний зардал	5,720,000
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	8,580,000
БОМТ-г хэлэлцүүлэх, тайлагнах зардал	-
Нийт	27,740,000

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2026 нийт зардалд 27,740,000 (хорин долоон сая) төгрөгийг төлөвлөв.

ДҮГНЭЛТ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлэх бөгөөд төслийг хэрэгжүүлэгч “Нутгийн Анар” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллана.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан.


“Нутгийн Анар” ХХК-ийн “Бүрэнцогтын гянтболдын орд ашиглах” төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг 2015, 2022 онд мөн 2019 онд тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлыг “Мон Газар Экологи” ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн байсан. “Нутгийн Анар” ХХК нь 2020, 2021, 2022, 2023, 2024 онуудад Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 5 дугаар багийн нутагт орших MV13470 тоот тусгай зөвшөөрөл бүхий Бүрэнцогтын гянтболдын ордыг эзэмшдэг “Нутгийн-Анар” ХХК нь үйл ажиллагаа явуулаагүй ба сумын засаг даргын тамга, гарын үсэг бүхий (хавсралт), 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөөний хүрээнд хийж гүйцэтгэсэн зарим ажлуудыг хавсаргав.

2022 онд хийгдсэн БОННУ-ний тайланд тусгасан төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОМТ)-ийн дагуу тухайн жилийн БОМТ-г хууль, журмын дагуу шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамжийг 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж өгөв.

“Нутгийн Анар” ХХК-ийн “Бүрэнцогтын гянтболдын орд ашиглах” төсөл нь Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 5-р багийн нутаг дэвсгэрт хэрэгжинэ. Төслийг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулж буй “Нутгийн Анар” ХХК нь тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 27,140,000 ба үүнд 2026 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал багтсан болно.

ХАВСРАЛТ

”Нутгийн Анар” ХХК нь 2019, 2020, 2022, 2023 , 2024 онуудад Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 5 дугаар багийн нутагт орших MV13470 тоот тусгай зөвшөөрөл бүхий Бүрэнцогтын гянтболдын ордыг эзэмшдэг “Нутгийн-Анар” ХХК нь үйл ажиллагаа явуулаагүй ба сумын засаг даргын тамга, гарын үсэг бүхий хавсралт.





СҮХБААТАР АЙМГИЙН
МӨНХХААН СУМЫН ЗАСАГ ДАРГА

22140 Баясгалант, Мөнххаан сум

2024.1.09 № 01/08
танай _____-ны № _____-т

АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАРТ

Тус сумын 5 дугаар багийн нутагт орших MV13470 тоот тусгай зөвшөөрөл бүхий Бүрэнцогтын гянтболдын ордыг эзэмшдэг “Нутгийн – Анар” ХХК нь 2023 онд үйл ажиллагаа явуулаагүй болно.



А. БАТДЭЛГЭР

О My doc A5/ blank



СҮХБААТАР АЙМГИЙН
МӨНХХААН СУМЫН ЗАСАГ ДАРГА

22140 Баясгалант, Мөнххаан сум

2023-01-23 № 01/26
танай _____-ны № _____-т


АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАРТ

Тус сумын 5 дугаар багийн нутагт орших MV13470 тоот тусгай зөвшөөрөл бүхий Бүрэнцогтын гянтболдын ордыг эзэмшдэг “Нутгийн – Анар” ХХК нь 2022 онд үйл ажиллагаа явуулаагүй болно.



А. БАТДЭЛГЭР

О My doc A5/ blank





СҮХБААТАР АЙМГИЙН
МӨНХХААН СУМЫН ЗАСАГ ДАРГА

22140 Баясгалант, Мөнххаан сум

2021.01.22 № 02/25
танай _____-ны № _____-т

АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАРТ

Тус сумын 5-р багийн нутагт орших MV13470 тоот тусгай зөвшөөрөл бүхий Бүрэнцогтын гянтболдын ордыг эзэмшдэг “НУТГИЙН АНАР” ХХК нь 2020 онд үйл ажиллагаа явуулаагүй болно.




Ю. БОЛОРТУЯА

o My doc a5/ balank

Нутгийн Анар ххк нь Байгаль орчныг хамгаалах чиглэлээр 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Тээврийн хэрэгсэлд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж байх.

2025 онд 5 тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгслийн оношилгоонд оруулж, засвар үйлчилгээг цаг тухай бүрд тогтмол хийж гүйцэтгэж байна.



Зураг 0-1. Техникийн хяналтын үзлэг

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Ариун цэврийн байгууламж, бохир усны цооног, хог хаягдлын цэг нийт 3 цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг ТОГТМОЛ хийж, орчныг бохирдуулахаас сэргийлж ажилласан.



Зураг 0-2. Ариутгал халдваргүйжил хийж буй байдал


Усан орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Төслийн хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн №175 тоот Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт (Зураг 0-3)-ийг Усны газраар гаргуулж, холбогдох ус ашиглуулах гэрээг байгуулан ажилласан.



Зураг 0-3. Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт

Усны хэрэглээг хангах 3 худагт хүйтэн усны тоолуур суурилуулж, мэргэжлийн байгууллагаар баталгаажуулан акт үйлдсэн (Зураг 0-4) бөгөөд шүүрлийн ус, унд ахуйн хэрэглээний усны тоолуур болон шугам хоолойн системийг суурилуулан ашиглаж байна (Зураг 0-5).



Зураг 0-4. Тоолуур баталгаажуулсан акт



Зураг 0-5. Суурилуулсан тоолууруудын харагдах байдал

Ус ашиглалт болон уурхайн шавхан зайлуулах усны хэмжээг тогтмол бүртгэж, холбогдох тайлан мэдээг хүргүүлэн, тухайн жилийн ус ашиглах дүгнэлт болон ус ашиглуулах гэрээнд заасан төлбөрийг бүрэн барагдуулсан.

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь хууль, эрх зүйн хүрээнд тусгайлан хязгаарласан болон хориглосон бүс, талбайд хамаарахгүй болно. Түүнчлэн айл өрхийн эзэмшил газар болон бэлчээрийн талбайтай давхцалгүй тул нүүлгэн шилжүүлэлт хийх, нөхөн олговор олгох шаардлага үүсэхгүй байна.

ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Газрын тухай хуулийн 56.6-д “Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана” мөн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-т “Аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх” гэж тусгасан байдаг. Түүнчлэн Монгол орон даяар Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах Монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж байгаа билээ.

Иймд 2025 оны БОМТ-ны хүрээнд элэгдэл, эвдрэлд өртсөн газрын нөхөн сэргээлт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 4 төрлийн 300 ширхэг мод тарьж, арчилгаа усалгааны ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Мод тарих өдрийг зохион байгуулахаас өмнө нарийн мод тарих төлөвлөгөөг гарган зааварчилгааны хамт ажилчдад хүргүүлсэн бөгөө үүний дагуу модны захиалгуудыг хийн ажиллаа.



Нутгийн анар ХХК

НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн талбайн ногоон байгууламжийн 2025 оны төлөвлөгөөний хүрээнд 300ш мод тарина.

1. МОДНЫ ТӨРӨЛ, ТАРИХ ТОО ХЭМЖЭЭ

2025 оны ногоон байгууламжийн хүрээнд дараах 3 төрлийн моднуудыг тарихаар төлөвлөж байна.



Улиас
(POPULUS ALBA)


- **Таних шинж:** 15-30 м хүртэл өндөр ургадаг, түргэн өсөлттэй мод бөгөөд шулуун иштэй, сааралдуу өнгийн холтостой. Залуу мөчир нь толгор, шаргал ногоон өнгөтэй байна. Навч нь өргөн, өндөррүү эсвэл гурвалжин хэлбэртэй, урт иштэй тул салхинд чичирхийлэн хөдөлдөг онцлогтой. Үр нь цагаан хэвнэлэг бүтэцтэй бөгөөд хаарын сүүд, зуны эхээр тархдаг.
- **Ургах орчин:** Гол мөрний хөндий, булаг шандын орчим, чийглэг хөрстэй газар, сайр жалга, элсэрхэг болон сул шороон хөрстэй талбайд ургана. Мод суурин газрын ногоон байгууламж, зам дагуу болон нөхөн сэргээлтний талбайд түгээмэл тарьж ургуулдаг.

2

2. ТАРИАЛАЛТ ХИЙХ АРГАЧЛАЛ

Суулгац сонгох: Тарих модны суулгацын өндөр 1.5м-с доошгүй, 2-3 буюу түүнээс дээш салаа мөчиртэй, жимс, жимсгэнийн суулгац 50см-ээс намгүй, 2-3 салаа мөчиртэй байх бөгөөд суулгацын үндэс гэмтээгүй хэвийн сайн, хөгжилтэй байна.


Нүхийг бэлтгэх: 70-80см голчтой, 50-60см гүн нүхэнд суулгацыг суулгана.




Суулгацыг нүхэнд суулах: Нүхэнд хийх шороог урьдчилан бууц, элстэй хольж бэлтгэнэ. Үүнд:

- Хар шороо - 50%
- Элс - 30%
- Бууц - 20%

Суулгацыг суулахын өмнө нүхийн талд хүртэл хольсон хар шороо хийгээд усална. Энэ усыг шингэхээр нүхийн шолд суулгацыг босгон барьж үндсийг нь жигд тараан байрлуулаад шорооны хөлийг дахин хийж усална. Усалгааны үе шингэмэгц хуурай шороо хийж сайтар гишгэж чигжинэ.



Усалгаа: Усалгааг системийг холбож дараах давтамжтай усалгааг хийнэ.
05/01-06/01: 7 хоногт 1 удаа
06/15-08/15: 7 хоногт 1 удаа
08/15-09/15: 7 хоногт 1 удаа
Газар хөлдөөхөс 2-3 долоо хоногийн өмнө: 7 хоногт 1 удаа



3

3. ТӨСӨВ

МОД ТАРИЛТЫН ТӨСӨВ

МОДНЫ ТӨРӨЛ	ТОО ШИРХЭГ	НЭГЖ МОДНЫ ӨРТӨГ, ТӨГ/Ш*	ОГНОО 5/10-8/16 НИЙТ ӨРТӨГ, ТӨГ
УЛИАС	400ш	5,125	2,050,000

4. ТОХИЖИЛТ

Үйлдвэрийн мод тарих талбайг дараах байдлаар тохижуулах боломжтой.

- **Явган хүний зам:** Явган хүний замыг цемент, хайрга зэргээр барилгын ажилтай давхцуулан хийх боломжтой байна.



- **Тохижилтын бусад хэсгүүд:** Мод тарисан талбайн урд хэсгээр ажилчид суух боломжтой сандалуудыг байршуулна. Хэмжээ, загварт суурилан захиалгаар аван суурилуулна.



- **Цэцгийн мандал:** Цэнэрлэгжүүлэлт, тохижилтын ажилд түгээмэл ашигладаг цэцгийн үрээр цэцгийн мандал хийхээр боломжтой:



КОСМОС



АЛАГ НҮДЭН
ВИОЛА



ХИЛЭН ЦЭЦЭГ



НАРАН ЦЭЦЭГ

4

Төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Нэг тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин уурхайн ашиглалтын талбай болон Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт “Шимт тал” хоршооноос худалдан авсан нийт 400 ширхэг улиасны суулгацыг тарьж, усалгаа, арчилгаа, хамгаалалтын ажлыг зохион байгуулан ажилласан.

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information				
Журналын/Journal No: 001328684046				
Системийн огноо/System Date: 2025.10.31 15:32:26				
Дт/ From	ИВАН/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5064702545	Б*****Ж БУД	2,050,000.00 MNT	1.00
/ Хоёр сая тавин мянган төгрөг /				
Кт/ To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name		
	34	State Bank - Төрийн банк		
	ИВАН/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name	2,050,000.00 MNT	1.00
	270900115027	ЖИМСТ ТАЛ ХОРШОО		
Гүйлгээний утга/Transaction description: нутгийн анар ХХК				
Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers				
Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:				
Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:				
Гарын үсэг/Signature:				
Тамга/Stamp:				
_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)				

Зураг 0-6. Худалдан авалтын баримт

Ингэснээр төлөвлөгөөнд тусгасан мод тарих ажлын тоон үзүүлэлтийг 100 ширхгээр давуулан биелүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтыг бүрэн ханган хэрэгжүүлсэн.



Зураг 0-7. Мод тарихтын ажлын явц